

МОНГОЛБАНКНЫ ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН МЭДЭЭЛЭЛ

Монголбанкны Хяналтын зөвлөлийн ээлжит хурал 2014 оны 03 дугаар сарын 18-нд хуралдаж, Монголбанкны Зөвлөлөөс 2014 онд гаргасан шийдвэр, түүний хэрэгжилтийн талаар Хяналтын зөвлөлийн гишүүн Ч.Энхбаатарын мэдээлэл, Хяналтын зөвлөлийн 2014 онд гаргасан шийдвэр, Монголбанкны удирдлагад өгсөн санал зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар зохиосон ажлын үр дүнгийн талаар Монголбанкны Тамгын газрын захирлын сонсгол, Монголбанкны дотоод хяналт, үйл ажиллагааны эрсдэлийн газрын 2014 онд хийсэн ажлын үр дүнгийн тухай тус газрын захирлын сонсгол, Хяналтын зөвлөлийн гишүүд Монголбанкны 2014 оны санхүүгийн тайланд аудит хийж буй аудиторуудтай санал солилцсон дүнгийн тухай гишүүн Ж.Үнэнбатын товч мэдээлэл зэргийг хэлэлцэв.

Монголбанкны газар, хэлтэс, албадад өгсөн үүрэг, даалгаврыг бүртгэх, биелүүлэх явцад тавих хяналт тогтмолжсоны үр дүнд Монголбанкны Захирлын зөвлөлийн хурлаас гаргасан шийдвэрийн хэрэгжилт тогтвортой сайн байгааг тэмдэглэж, Монголбанкны Хяналтын зөвлөлөөс 2012-2014 онд гаргаж хүргүүлсэн санал, зөвлөмжийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, зарим санал, зөвлөмжийн гүйцэтгэлийг биелсэн гэж дүгнэж буй ч шаардлагатай хэмжээнд хүртэл хийгдээгүй байгаад анхаарч ажиллах, ДХҮАЭГ-ын 2014 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайланд үйл ажиллагааны эрсдэлийн чиглэлээр хийсэн ажил, түүний үр дүн тодорхой биш байгаа тул уг чиглэлд анхаарч, зохих арга хэмжээ авах, Үйл ажиллагааны эрсдэлийн хэлтсийн чиг үүргийг оновчтой байдлаар зохион байгуулах боломжийг судалж хэрэгжүүлэх зэрэг шийдвэр гаргав.

Дээрх асуудлаар Монголбанкны Ерөнхийлөгчид зөвлөмж хүргүүлэв.

МОНГОЛБАНКНЫ ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛ